

Дүрэмт хувцасны журам

Сурагчдын хувцаслалтын дүрэм нь манай сургуулийн соёлын чухал хэсэг юм. Иймээс дүрэмт хувцасны журмыг хичээлийн жилийн турш мөрдөнө. Сурагчдын дүрэмт хувцсыг Даваа-Пүрэв гарагуудад өмсөх журамтай. Баасан гарагт энгийн хувцаслаж болно. Сурагчдыг үсээ содон өнгөөр будах, мөн сургууль дээр малгай өмсөхийг хориглоно.

Дүрэмт хувцас:

- Сургуулийн лого бүхий цахилгаантай гадуур цамц
- Сургуулийн лого бүхий цахилгаантай гадуур малгайтай цамц
- Сургуулийн лого бүхий урт болон богино ханцуйтай поло цамц
- Хөвгүүд сургуулийн лого бүхий хар хөх өнгийн өмд, харин охид сургуулийн лого бүхий хар хөх өнгийн өмд болон сургуулийн лого бүхий хар хөх өнгийн юбка, хар өнгийн трико/ретузны хамт өмсөнө.
- **Зураас гаргадаггүй** хар өнгийн гутал, ботинк эсвэл дээгүүрээ цул хар ба цагаан ултай гутал. Гутал дээр бага хэмжээний цагаан болон саарал өнгийн лого байж болно.
- Зураг тод өнгийн чимэглэл, төмөр тоног зэрэггүй байна.
- Онцгой тохиолдолд багаар эсвэл ангиараа захиалан өмсөх малгайтай цамц/гадуур цамц зэргийг өмсөх үед дотуур нь заавал дүрэмт хувцас өмсөнө.

Дүрэмт хувцасны дүрмийг зөрчсөн тохиолдолд:

- Эцэг эхүүдийг дуудах болон солих хувцас авчруулна.
- Сурагчид тэр өдрийн хичээлд суухгүй ба хичээлээс түдгэлзүүлэх болно.
- Удаа дараалан дүрэм зөрчсөн тохиолдолд гэрт нь буцаана эсвэл хичээлээс сургуулийн байранд хамгийн багадаа нэг өдөр түдгэлзүүлэх болно.

Шаардлагад нийцсэн хувцас өмсүүлэх нь эцэг эхийн үүрэг юм.

Баасан гарагт энгийн хувцаслаж болно. Хэрэв сурагчийн энгийн хувцаслалт нь зүй зохисгүйд тооцогдох аваас гэр лүү нь буцаана. Дүрэмт хувцас болон хувцаслалтын дүрэмтэй холбоотой асуулт, тодруулах зүйл байвал Сургалтын Албанд хандана уу.

Өмсөх хориотой:

- Урагдсан хувцас
- Хүзүүний шугамаас өвдөг хүртэлх ямар нэгэн арьсыг ил гаргасан хувцас (жиш: хэт богино цамц)
- Богино юбка, богино цамц, хэт бариу цамц, майк
- Садар самууныг сурталчилсан эсвэл сэтгэл түгшээсэн агуулгатай бичигтэй хувцас

Хөвгүүдийн дүрэмт хувцас

			
	 <p>Зураас гаргадаггүй !</p>	 <p>Зураас гаргадаггүй !</p>	 <p>Зураас гаргадаггүй !</p>

Охидын дүрэмт хувцас

			
	 <p>Зураас гаргадаггүй !</p>	 <p>Зураас гаргадаггүй !</p>	 <p>Зураас гаргадаггүй !</p>